

## Маргааны товч

**2022.03.15-ны** өдрийн Бүтээгдэхүүний загварын шүүлтийн дүгнэлтээр “Magic spoon” бренд Зөгийн бал, шар тос, чацарганы охьтой халбаганы иж бүрдлийн бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт шүүлт хийж, уг бүтээгдэхүүний шошго болон савлагааны хэвлэмэл загварыг бүртгэж, патент олгохоор шийдвэрлэжээ.

**2022.10.10-ны** өдрийн ОӨГ-ын даргын А/148 дугаар тушаалаар “Пропел” ХХК-ийн дугаартай мэдүүлэг бүхий “Халбаганд савлагаатай хүнсний сав баглаа боодлын загвар”-т бүтээгдэхүүний загварын патент олгосон.

Нэхэмжлэгч хуулийн этгээдээс: “... манай компани Халбага шар тос гэсэн бүтээгдэхүүн анхдагч огноогоор буюу 2021 оны 07 сараас эхлэн худалдаанд гаргаж, байгууллагын цахим хуудаст нийтлэгдэж нийтэд илэрхий болсон, манай бүтээгдэхүүн гарснаас хойш гуравдагч этгээдийн ижил төстэй бүтээгдэхүүнд патент олгосон нь хууль бус...” гэж,

Хариуцагчаас “... хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах сав баглаа боолын хэлбэр хийц, өнгө өнгөний хослол, онцлог ялгаатай харагдуулж буй тэрхүү шийдлүүд хоорондоо давхцаагүй, ялгаатай бүтээгдэхүүнүүд байсан, супер маркетуудад анх худалдан борлуулагдаж байсан гэх үйл ажиллагаа, Монгол Улсад анх удаа халбаганд бүтээгдэхүүнийг савлаж худалдаанд гаргасан зэрэг нь оюуны өмчийн аль ч салбараар хамгаалагдахгүй...”

Гуравдагч этгээд “Жаргалант Харвест” ХХК-иас “... зөгийн бал, шар тос зэрэг хоорондоо ижил төстэй харагдуулах шинж, загвар дүрслэл байхгүй гэж мэргэжлийн байгууллагаас шат дараалан дүгнэлт гаргасан тул нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн зүйл байхгүй, “Пропел” ХХК-ийн мэдүүлгийн анхдагч огноо 2021.09.27-ны өдөр бол “Жаргалант Харвест” ХХК-ийн мэдүүлгийн анхдагч огноо 2021.08.09-ний өдөр тул түрүүлж хамгаалагдана...” гэж тус тус маргасан.